



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Г “Мах” бондыг бүртгэлээс хасах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаст Агро” ХХК-иас гаргасан 12 сарын хугацаатай, жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 439,954 /дөрвөн зуун гучин есөн мянга есөн зуун тавин дөрөв/ ширхэг “Мах” бондын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн барагдсан байх тул үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Хөвсгөл мах маркет” үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанаас чөлөөлөхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Жаст агро” ХХК /Т.Содномдаржаа/, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000410